

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

7-36

1.Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төсөл /Засгийн газар 2025.07.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

8-14

2.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай/

14-18

3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

19-32

4.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

32-34

5.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

34

6.Байнгын хорооны даргыг сонгох тухай

34-36

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
07 дугаар сарын 07-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, М.Нарантуяа-Нара,
С.Эрдэнэболд;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг.

Нэг.Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төсөл /Засгийн газар 2025.07.02-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, шинжээч Х.Дөлгөөн, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир, мөн газрын Интерполлын Үндэсний төв товчооны Ажлын албаны дарга Н.Баясгалан, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Гэрээний төслийн танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Д.Ганбат, Да.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 15 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Г.Нарантуяа, С.Дондов, Тамгын газрын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээ хариуцсан ахлах референт Ч.Ариунаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, О.Номинчимэг, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, О.Номинчимэг нарын саналыг тусган чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт, төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн дарга С.Очирбат, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Ө.Жамбалсүрэн, Хуульч, судлаач Д.Нагважамц нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Б.Энхбаяр, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт, төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн дарга С.Очирбат, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Ө.Жамбалсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Одонтуяа, П.Сайнзориг, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

1.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 2

Бүгд: 16

87.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг хүчингүй болсонтой холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах санал гаргасан талаар танилцуулав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар тогтоолын төслийг Байнгын хорооны гишүүдэд тараасан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Бүгд: 16
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 43 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 20 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Ингээд Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Байнгын хорооны хуралдааны ирц Дамдины Цогтбаатар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Лхагвын Мөнхбаатар, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр гэсэн гишүүдийн ирцтэйгээр 59 аравны, Одонтуяа гишүүн сая орж ирж ирцдээ орж байна. Ингээд 59.1 хувийн ирцтэйгээр хуралдааны ирц бүрдсэн байна. Хуралдаан нээгдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дэх асуудал. Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улсын болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төсөл. Монгол Улсын Засгийн газраас 7 дугаар сарын 2-ны өдөр, энэ оны 7 дугаар сарын 2-ны өдөр ирүүлсэн зөвшилцөх. Санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр ийм зохицуулалттай ийм гэрээ орж ирж байна.

2.“Монгол Улсын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Батчимэг нарын 9 гишүүнээс 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэнэ.

4.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн ийм төсөл байгаа. Хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 6 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

6.Бусад асуудал гэсэн ийм асуудлууд байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд, санал хэлэх гишүүд нэрсээ нэрсээ өгнө үү.

Байхгүй байна. Тэгэхлээр хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэгдүгээр асуудал. Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төслийг хэлэлцье.

Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улсын хоорондын гэрээний төслийн танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Лхагвын Мөнхбаатар танилцуулна. Мөнхбаатар сайдын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хэрээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аяллын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан Монголчуудын зорчиж, амьдарч, ажил, хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

Бүгд Найрамдах Киргиз Улстай, Монгол Улс Бүгд Найрамдах Киргиз Улсын хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг 1999 онд байгуулсан бөгөөд уг гэрээнд гэмт этгээдийг шилжүүлэхтэй холбогдох харилцааг ерөнхий байдлаар зохицуулсан байсан.

Дээрх харилцааг илүү тодорхой нарийвчлан зохицуулах тухай саналыг анх Киргизийн талаас гаргаж, гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төслийг ирүүлсэн бөгөөд манай талаас өөрийн саналыг хүргүүлж хамтран ажилласнаар талууд гэрээний төслийг эцэслэн тохироод байна.

Энэхүү гэрээний төсөл нь 25 зүйлтэй бөгөөд харилцах эрх бүхий төв байгууллага шилжүүлэн өгөх гэмт хэрэг, шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд тавигдах шаардлага, холбогдох баримт бичиг шилжүүлэн өгөхөөс татгалзах үндэслэлд шилжүүлэн өгөх шийдвэрийг гаргах, шилжүүлэн өгөх хүсэлтийг хойшлуулах зардал гэх зэрэг гэмт этгээд шилжүүлэх ажиллагаанд хамаарах үндсэн асуудлаас гадна талууд гэрээний хүрээнд олж авсан аливаа мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг дотоодын хууль тогтоомжийн дагуу хадгалж, хамгаалахтай холбогдох зохицуулалтыг төсөлд тусгалаа.

Гэрээг байгуулснаар 2 улсын хууль хяналтын эрх бүхий байгууллагууд гэмт этгээдийг олж тогтоох, шилжүүлэн өгөх, хариуцлага хүлээлгэх асуудлаар хоорондоо шууд харилцаж, шуурхай арга хэмжээ авч хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Энэхүү гэрээ нь олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

зүйлийн 8.1.4-д заасны дагуу заавал соёрхон батлах гэрээ бөгөөд уг гэрээг Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох байгууллагуудтай зөвшилцөхөөр шийдвэрлэсэн болно.

Иймд холбогдох журмын дагуу гэрээ байгуулахыг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Д.Цогтбаатар: Мөнхбаатар сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүйн яамнаас Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Нарантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын шинжээч Дөлгөөн, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, бригадын генерал Ням-Очир, Цагдаагийн ерөнхий газрын Интерполын Үндэсний төв товчооны ажлын албаны дарга, цагдаагийн хурандаа Баясгалан гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг энэ хуралдаанд оролцож байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Бүгд Найрамдах Киргиз Улстай гэмт этгээд шилжүүлэх тухай Засгийн газар хоорондын гэрээний төслийг илүү тодотгож нарийн болгож байгаа юм байна гэж ойлголоо. Ер нь ерөнхий асуулт асууя. Манай улс ер нь хэчнээн гадаадын улс оронтой энэ гэмт этгээд шилжүүлэх ийм гэрээтэй байдаг юм бэ? Манай улсаас одоогийн байдлаар ер нь бусад улс оронд хэчнээн иргэн ял эдэлж байна вэ? Өнгөрсөн хугацаанд хэчнээн ийм ял эдэлж байгаа иргэдээс Засгийн газар хоорондын гэрээгээр гэмт этгээдүүдийг шилжүүлж аваад байгаа вэ? Ер нь авч чадахгүй байгаа иргэд бас байдаг юм билээ. Өнгөрсөн хугацаанд миний бие бас Хууль зүйн яаманд хандаж дүүргийнхээ 1 иргэний асуудлыг шийдүүлэх гээд шийдүүлж чадаагүй Хятад Ард Улсад ял эдэлж байгаа. Ингээд асуудлыг шийдүүлж чадахгүй байсаар байгаад хугацааг нь өнгөрөөсөн асуудал бий. Эмэгтэй хүний асуудал. Яг хэрэг болгон дээр бас шилжүүлж авч чаддаггүй юм байна лээ шүү дээ. Энэ сумны асуудал, зэвсэг нийлүүлсэн гэдгээр цүнхэнд нь 1 сум явж байгаад ингээд хоригдоод баригдаад ингээд асуудал үүсчихсэн асуудал байдаг юм.

Тэгэхээр одоо Киргиз Улсад ер нь хэчнээн Монгол иргэн ял эдэлж байгаа юм? Энэ асуудал нь хэдийгээр шийдэгдэх бололцоотой байгаа юм, манай улсад бас гадаадын хэчнээн иргэн ял эдэлж байна вэ? Энэ Засгийн газар хоорондын гэрээгээрээ шилжүүлэгдэж байгаа юу, шилжүүлэгдэхгүй байна уу? Ер нь ямар процедураар энэ асуудлуудыг шийддэг юм? Энэ дээр хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: Мөнхбаатар сайдын микрофоныг өгье.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь 2 талт олон улсын гэрээнүүд ярьж байгаа. Ерөнхийдөө Сандаг-Очир гишүүний хэлсэн тэр агуулгаар буюу ерөнхий гэрээг нарийвчилж байгаа ийм зохицуулалтуудыг тусгасан ийм гэрээ байгаа юм. Одоогийн байдлаар Монгол Улс 22 улстай 40 эрүүгийн болоод иргэний чиглэлээр харилцан туслалцаа үзүүлэх ийм гэрээ байгуулсан байгаа. Энэ дотор нь эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх гэрээ 18 байна. Гэмт этгээд шилжүүлэх харилцааг зохицуулсан гэрээ 16 байгаа. Ялтан шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан гэрээ 11 хүчин төгөлдөр үйлчилж байгаа юм.

Одоо Тайланд болоод Малайз Улстай бас энэ гэрээг хийхээр бид бэлтгэж байгаа гэдгийг бас танд хэлье. Ер нь энэ иргэний хэрэгт жил орчим дунджаар 50 орчим эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ийм хүсэлт ирж ажиллагаа хийгддэг иргэний хэрэг дээр. Эрүүгийн хэрэгт 20 орчим эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлт ирээд түүнийг нь 2 талаасаа хэлэлцэж байгаа. Ялтан шилжүүлэх тухай 33 иргэний ийм хүсэлт ирсэн. Эдгээр ажиллагааг нь хийгдэж байна. Эдгээр нь ихэнх нь 27 нь БНХАУ-д ял эдэлж байгаа Монгол Улсын иргэдийн хүсэлт байгаа. 6 нь Монгол Улсад хориход эдэлж байгаа Хятад Улсын иргэдийн хүсэлт байх жишээтэй байна.

Ер нь энэ 2009-өөс 23 оны хооронд нийт 19 иргэнийг Хятадын талаас ялтныг шилжүүлэн авсан ийм мэдээлэл байгаа. Одоо нийтдээ энэ 7 хүсэлтэд холбогдох ажиллагааг ингээд хийгээд явж байгаа юм байна лээ. Сая та бас асуусан энэ яг Киргизтэй манайх ийм харилцаа идэвхтэй явж байгаа юм л даа. Иргэдийн шилжилт хөдөлгөөн сүүлийн 3 жилийн байдлаар 3037 иргэн манай улсын иргэн зорчсон. Киргиз Улсын 4362 иргэн сүүлийн 3 жил ингээд зорчсон байгаа. Хоорондоо харилцаа байнга нэмэгдэж байгаа гэсэн үг. Хөдөлгөөн нэмэгдсэн гэж ойлгож болно. Манайхаас 150 гаруй иргэн Киргиз Улсад ажил, хөдөлмөр эрхлээд байнгын оршин сууж сууж байна. Киргиз Улсын 75 иргэн манай дээр сууж байгаа, байнга оршин сууж байгаа, энд суралцаж байгаа, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа бусад шалтгаанаар сууж байгаа гэж ойлгож болно. Хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн үг.

Одоо Киргизтэй мэдээж харилцаа нэмэгдэж байгаа. Зорчих хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбогдуулаад энэ гэрээнүүдийг харилцан сайжруулах шаардлага байгаа. Энэ дотор Киргизээс чинь нийтдээ хэдэн хүн байлаа одоохон би үзээдэхье. Киргиз Улсаас интерполын шугамаар улаан буланд зар мэдээгээр зарлуулсан Монгол Улсын 2 иргэн байгаа. Энийг улам шилжүүлэн авчирсан. Киргизээс бас ер нь бас 2 иргэний хувьд Киргизээс Улсаас 1 иргэн, мөн манай улсаас бас Киргизийн иргэнийг бас хүлээлгэж өгсөн 1 иргэнийг Интерполын төвд очиж хамтраад Монгол Улсаас албадан гаргасан болон бусад тухайн улсад хүргүүлсэн ийм мэдээлэл байна гэдгийг танд хэлье.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Сүүлийн үед ер нь иргэд гадагшаа, дотогшоо их явдагтай болсонтой холбогдуулж санамсар болгоомжгүйгээсээ болж хэн нэгний хэлсэн ачаа, тээшийг авч явах, дайвар юмнууд авч явж байгаад ингээд хар тамхи, мансууруулах бодисын төрлийн юмнуудыг нуун далдалж орж ирэх, гаргах ийм асуудлууд бас их нэмэгдэж байгаа гэдэг ийм мэдээллүүд яваа.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Тийм учраас цаашдаа энэ иргэдэд энэ хүний ачаа тээвэр, дайвар бүтээгдэхүүнийг авч явах талын асуудлыг бас Хууль зүйн яам, хил, гаалийн байгууллагууд чангатгахгүй санамсар болгоомжгүйгээсээ болоод, мэдээгүйгээсээ болоод зүгээр танил тал, найз нөхдийнхөө хүрээнд ингээд энийг аваад явчих гэснийхээ хүрээнд ингээд хэрэгтэн болох асуудлууд их байгаа. Тэгээд энэ дээр, нөгөө талаас манай улс ингээд шилжүүлэх асуудлынхаа хүрээнд шилжүүлж авчхаад үүргээ биелүүлдэггүй тухайн иргэдийг ялыг нь эдлүүлдэггүй гаргачихдаг асуудал бас байдаг юм байна лээ. Энд нь нөгөө тал гэрээ байгуулсан тал бас их дургүйцдэг хандлага байдаг юм байна лээ.

Д.Цогтбаатар: Мөнхбаатар сайдын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Ер нь Монгол Улсын иргэд бас тухайн улсын хэрэглэгч нар Монгол Улс руу нэвтрэхдээ бусдын ачаа тээшийг бас дамжуулан авч авдаг, хил нэвтрүүлдэг, үүнийхээ улмаас бас хар тамхи болоод хориотой, хууль бус бас эд зүйлийг нэвтрүүлсэн ийм хэрэгт холбогдох зүйл нэлээд гарч байгаа. Энэ талаар мэдээж тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурталчилгаа, таниулга хийх ийм ажлууд хийгдэнэ, хийгдчихэж байгаа. Цаашид энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа. Ер нь иймэрхүү тохиолдлууд бас удаа дараа гараад байгаа. Энэ чиглэлээр Ням-Очир генерал тодорхой бас нэмэлт мэдээлэл өгчих.

Д.Цогтбаатар: 7 дугаар микрофон.

Ц.Ням-Очир: Бид нар энэ, Сандаг-Очир гишүүн гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагаас иргэддээ анхааруулж сэрэмжлүүлж байгаа олон ажлын нэг бас яг энэ дайвар ачааны чиглэлийн юм байгаа. Энэ дээр тийз дээр бас бид нар нэлээдгүй бас анхаарч хамтарч ажиллаад тийз дээр урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа. Дээр нь онгоцонд бас өгч байгаа, МИАТ-ийн тэр онгоцонд тараадаг ном хэвлэлд бас яг энэ сэрэмжлүүлэх чиглэлийн юмнуудыг өгсөн байгаа. Энэ Киргиз Улсаас яг энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн, шалгагдсан зүйл байхгүй.

Харин Интерполын хөх булантаар зар мэдээгээр олон улсад эрэн сурвалжлагдаж байсан Содном гэдэг нь энэ оны 6 сарын 30-ны өдөр Бүгд Найрамдах Турк Улсаас албадан авчирсан. Энэ дээр бас яг дайвар ачаа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? 7 дугаар микрофон.

Ц.Ням-Очир: Турк Улсаас бид нар энэ “С” гэдэг нөхрийг энэ сарын, 6 сарын 30-ны өдөр албадан авчирсан. Энэ яг энэ дайвар ачаа, бусдад дайвар ачаа өгч, хар тамхи мансууруулах бодисоос хил хууль бусаар нэвтрүүлдэг үйлдлийг таслан зогсоосон байгаа. Танилцуулж дууслаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Би ганц асуулт асуучихъя их товчхон. Энэ Мөнхбаатар сайд аа өмнө нь энэ байгуулсан байсан гэрээг, текстийг нь шинэчлээд оруулж ирж байгаа юм байна шүү дээ. Би зүгээр тэн дээр холбогдуулаад 1969 оны Венийн гэрээний тухай конвенцын дагуу, ер нь Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу гэрээг өөрийг нь шинэчлээд явах зохицуулалт байдаг. Ихэнх гэрээнүүд өөртөө гэрээг шаардлагатай шинэчлэлийг хийх зохицуулалтуудыг

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

өөртөө шингээсэн байдаг. Энэ тэгээд ороод ирж болоогүй юм уу? Яагаад энэ ингэж текстийг шинэчилж оруулж ирж байгаа юм бол? Тэнд гэнэт илүү их тийм гэмт хэргийн нөхцөл байдал өөрчлөгдөөд зүгээр нэмэлтээр өөрчлөх боломжгүй болсон юм болов уу, яасан юм бол?

Мөнхбаатар сайдын микрофоныг.

Л.Мөнхбаатар: Ер нь 1999 онд энэ эрх зүйн туслалцаа үзүүлэх энэ гэрээгээ байгуулсан юм байна лээ. Тухайн үед бас манай анхны гэрээнүүдийн байх байгаа. Цогтбаатар дарга бас мэдэж байгаа. Энэ гэрээнүүдийг ер нь цаашдаа нийтдээ энэ гэмт этгээдийг шилжүүлэх тухай 16 гэрээ байгуулсан. Энэ өмнө хуучин байгуулсан энэ гэрээнүүдийг илүү тодорхой болгох, түрүүний дурдсан энэ олон нарийвчилсан зохицуулалтуудыг бий болгох шаардлага байгаад байгаа юм Цогтбаатар дарга. Энэ дээр энэ шилжүүлэн өгөх хүсэлтээ хэрхэн шийдвэрлэх юм, зардалтай холбоотой асуудлаа яах юм, татгалзах үндэслэл, шилжүүлэн өгөхгүй байх тодорхой гэмт хэргүүдтэй холбоотой энэ асуудлуудыг нэг бүрчлэн нарийвчлаад цаашдаа яг энэ асуудлуудаар ерөнхий гэрээнээс гадна ерөнхий гэрээнүүдийг ер нь эрүүгийн чиглэлээр ч тэр, иргэний чиглэлээр ч тэр ер нь нарийвчлан ингэж байгуулаад явах нь зүйтэй юм байна. Энэ нь илүү 2 талдаа хамтын ажиллагаанд ч тэр, энэ асуудлыг шийдвэрлэхэд илүүл нарийвчилсан зохицуулалттай байлгаж тусгайлан ингээд байгуулаад явах нь зүйтэй байна гэж үзэж байгаа.

Ер нь бид нарын анхны байгуулсан, 90-ээд оноос хойш байгуулсан анхны гэрээнүүд хэт ерөнхий зохицуулалттай байгаа. Яг түүгээр асуудлыг шийдье гэхээр тухайн дотоодын хууль тогтоомж олон зүйлтэй зөрчилдөөд байгаа учраас энэ асуудлыг нарийвчлаад цаашдаа ч гэсэн энэ тусгайлсан гэмт этгээдийг шилжүүлэхтэй холбоотой, ялтан шилжүүлэхтэй холбоотой, эрүү, иргэнтэй эрх зүйн харилцан туслалцаа хэрэглэх гэрээг ингэж байгуулаад явах ийм бодлого барьж байгаа гэдгээ хэлье.

Д.Цогтбаатар: Баярлалаа дарга. Би зүгээр энийг асууж байгаа нь нэмэлт, өөрчлөлт болох, эс үгүй бол шинэ гэрээ 2 чинь процедурын хувьд жоохон өөр болоод явчхаж байна шүү дээ. Тийм шаардлага байгааг ойлголоо.

Асуулт асууж гишүүд хариулт авч дууслаа.

Гэрээний төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би бас яг энэ сая гишүүдийн хэлж байгаатай санал нэг байна. Ялангуяа Сандаг-Очир гишүүний. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг одоо бас тодорхой түвшинд нь тийзийн үйлчилгээ, тийз бичдэг үйлчилгээ үзүүлж байгаа болон авиа компаниудтай ингээд хамтарч байгаагаас гадна ер нь аль болох багаас нь яг энэ сургуулийн боловсролын хөтөлбөр энэ тэрд оруулмаар байгаа юм. Яг энэ жүжигчилсэн гэдэг юм уу, яг өөрт нь ойлгуулах байдлаар хүний ерөөсөө ачааг авч явдаггүй иймэрхүү зүйлүүдийг ингээд багаас нь дадал болгоод сургахад бас анхаармаар байна. Түүнээс биш насанд хүрсэн хүмүүстэй яг ажиллана гэхэд хэцүү байдаг. Би ч гэсэн ингээд л ийш тийшээ явж байхаар хэцүү байдаг байхгүй юу. Монголчууд яг ингээд л бие биеэ хараад л яаралтай юм байгаа энэ тэр гээд л байдаг. Яг үнэндээ хэлэхэд боломжгүй гээд л хэлж сурч байгаа юм.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Тэгэхдээ яг ингээд хүмүүс чинь бас бие биеэ хараад л жоохон өрөвч сэтгэлгээнд гэнэн царайлна, тэгээд дотор нь юу байгаа нь мэдэгдэхгүй ийм зүйлүүд бие биедээ дайх гэж энд тэнд явж байхад их оролдоно. Тэгэхээр энийг аль болохоор тэр багаас нь сургадаг тийм л зүйл рүү оруулах хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй бол манайхан чинь бас заримдаа хэнэггүй, заримдаа тусалчихъя гэнэ, заримдаа гэнэн байна. Янз янзын юу гэдэг юм хөөрхий гадагшаа, дотогшоо анх удаа явж байгаа хүмүүсийг чинь тийм хүмүүс чинь илүү их онилдог юм байна лээ шүү дээ.

Тэгээд ийм зүйлүүд байгаа учраас бас энийг илүү их ерөнхий боловсролын тэр агуулга, хөтөлбөрт нь оруулах, магадгүй тэр иргэний боловсролын хичээл дээр л оруулж өгөх ёстой байхгүй юу нэг агуулга. Тэгэхээр бид хэд ингээд ЕБС-д оруулах гэхээр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хичээл гэж оруулчих гээд үзээд байдаг. Уг нь бусад хичээлүүдийн агуулга, хөтөлбөрөөр яаж энийгээ дамжуулж тэр зөв зан үйл, дадлын оруулах вэ гэдэг зүйлийг л бид нар Боловсролын яамтайгаа маш сайн хийж байх ёстой юм. Тэгээд иргэний боловсролын хичээл дээр нь наад захын бид нар энэ гадагшаа зорчих асуудал дээр юуг хамгийн түрүүнд шалгадаг гэдгээс ингээд л хүүхдүүдэд сургаж өгмөөр байгаа байхгүй юу. Тэгээд энэ чиглэлдээ бас анхаараарай гэдэг зүйлийг хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Би ганц юм нээрээ хэлчихье. Сая энэ хар тамхитай холбогдуулаад ярьж байна шүү дээ. Афганистан бол Колумбын Наркакартель дарагдсанаас хойш Афганистан дэлхийн хар тамхины нийлүүлэлтийн ихэнх хувь Афганистан руу шилжсэн манай хууль хяналтынхан сайн мэдэж байгаа. Киргизээр дайрч явдаг замыг чинь нортрөүд/north road/ буюу хойд зам гээд Европ руу яг дайрч явдаг гол замд нь байгаа учраас энэ дээр нээрээ сая энэ Сандаг-Очир гишүүн, Сайнзориг гишүүний хэлж байгаа энэ урьдчилан сэргийлэлт юман дээрээ нээрээ та нар онцгой анхаарахгүй бол энэ зүгээр нэг тохиолдлын юм биш шүү. Энэ ингээд гарч байна гэдэг чинь өөрөө тэр том магистрал зам дээр оршиж байгаа орон учраас энэ гэрээг тэр ч утгаараа ингэж бүүр цоо шинээр хийж байгаа нь зөв байж магадгүй гэж бодож байгаа шүү. Энийг анхаарцгаана биз.

Гэрээний төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төслийг бүхэлд нь зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

53.3 хувиар санал дэмжигдлээ.

Баасанжаргал гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Ганбат гишүүнийг бас саналд оруулаарай. Дэмжсэн саналд оруулаарай. Санал хураалтын дүнг танилцууллаа.

Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээний төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин танилцуулна.

Дараагийн асуудалд оръё.

12.41 цаг

Хоёр дахь асуудал “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 8 дугаар тогтоолоор “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Уг ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр ахалж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг гишүүн нар ажилласан бөгөөд тус ажлын хэсгээс боловсруулсан тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Энд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Энхбаяр ажлын хэсгийн дарга Энхбаяр гишүүн танилцуулга хийнэ гэсэн байгаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 25 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн миний бие, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг нар ажилласан.

Ажлын хэсэг 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр хуралдаж, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тайлангийн зөвлөмж, саналын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллуулахыг Засгийн газарт даалгасан хэлбэрээр боловсруулж бэлдлээ. Үүнд:

Сонгох, сонгогдох эрхийн талаар.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

2.Хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар.

3.Хүний эрх ба цахим технологийн талаар.

4.Цахим орчинд үйлдэгдэж байгаа жендерт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар.

5.Бэлгийн хүчирхийллийн хохирогч, хүүхдийн эрхийг хамгаалах талаар.

6.Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар.

7.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар тус тус саналыг боловсруулж бэлтгэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүнд баярлалаа. Энэ тогтоолын төслийг хэлэлцэхтэй холбогдуулан ажлын хэсэг энд хүрэлцэн ирсэн байгаа. Ажлын хэсэгт Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Нарантуяа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Дондов, Хүний эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, шинжилгээ хариуцсан ахлах референт Ариунаа гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын Өргөдөл, гомдол хариуцсан хэлтсийн дарга Ууганбаяр бас ирж оролцож байна.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Тэгье. Би Хүний эрхийн Комиссоос ганц асуулт асуугаадахъя. Энэ хүний эрхийн нөхцөл байдлын тухай илтгэлийг Женев эд нарт хэлэлцүүлж байхад нэг яригдаад байгаа бас асуудал шүүхийн ил тод байдалтай холбоотой асуудлууд нэлээн яригдаж байгаа. Тэгээд энэ дээр бидний зүгээс, Их Хурлын зүгээс энийгээ ил тод байлга, олон улсын түвшинд ийм асуудал гаргахгүй байлгахын төлөө бид нар арга хэмжээгээ аваад л явж байгаа юм. Зүгээр Хүний эрхийн Комиссоос энэ чиглэлээр тавьж байгаа зөвлөмжүүдийг шат шатандаа хэр авч байгаа вэ? Жишээлбэл, яг танай тодорхой яг энэ асуудлаар тавиад байхад авч хэрэгжүүлээгүй байгаа ямар нэгэн тийм асуудал байна уу?

Сүнжид даргын микрофоныг өгье. 6 дугаар микрофон.

Д.Сүнжид: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Шударгаар шүүлгэх эрхтэй холбоотой өмнөх 49, 35 дугаар

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

тогтоолуудад ямар заалт болсон бэ гэхээр эрүүгийн, эрүү шүүлт тулгасан гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг явуулах бие даасан нэгжийг байгуулаач гэдгийг UPR-ын хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлгийн зөвлөмжид өгсөн. Үүний дагуу энэ хэсэг дээр бид нар нэгдүгээрт эрүү шүүлт тулгах гэмт хэргийг Эрүүгийн хууль дээр илүү тодорхой болгох хэрэгтэй байна гэдэг нэг зөвлөмж.

Хоёр дахь нь хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг ялгаварлан гадуурхах, доромжлох гэдгийг эрүү шүүлт тулгахаас ялгаж томьёолох хэрэгтэй байна гээд хоёр дахь зөвлөмж.

Гурав дахь нь энэ мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагыг судалж байгуулаач гээд ийм 3 дахь зөвлөмж өгсөн юм. Тэгээд өмнөх хэсгүүд нь хэрэгжчихсэн. Одоо Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд энэ шүүгчийн зөвшөөрөлгүйгээр буюу шүүгчид мэдэгдэхгүйгээр баривчлах, цагдан хорих энэ асуудлыг бүрэн процессынхоо хувьд шийдээд явчихсан. Харин саяын хэлсэн 3 зүйл дээр зарим нь, 2 нь одоо энэ тогтоолын төсөлд орж ирж байгаа тэр 1 байгууллагын асуудал тусгагдаагүй хэвээр байгаа.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Тэгэхлээр тэр 1 үлдсэн асуудал дээрээ яг надтай орж ирээд тусгайлан суугаад дараагийн алхмууд юу хийх вэ гээд тэгвэл надтай санал хуваалцаарай. Энэний дараа тэгвэл энийг тодорхой ярья. Бусад асуудал нь тогтоолын төсөлд орчихсон байгаа юм байна шүү дээ Энхбаяр дарга. Энэ ч үгүй үгүй би Хүний эрхийн Үндэсний Комисс эднийх өөрийнхөө зөвлөмжийг өгөөд манай зөвлөмжөөс 1 нь бас гүйцэд шийдэгдээгүй байна. Тийм. Ажлын хэсгийн дарга мэдээж хэрэг хамт орж ирэх нь зөв. Тийм.

Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Байнгын хорооныхоо гишүүдэд өдрийн мэнд хүргэе. Энэ ч 5, 6 хуудасны нэлээн том тогтоол орж ирж байгаа юм байна. Зөвхөн юунд юм байна тийм үү? Засгийн газарт даалгаж байгаа юм байна. Нэлээн нарийвчилсан угаасаа зөвлөмжүүд нь илтгэлтэй холбоотой ороод ирчихсэн. Тэгээд Хүний эрхийн Комиссынхон өөрсдөө маш сайн ажилласан гэж ойлголоо. Энэ дээр ингээд харахаар энэ нөгөө сонгох, сонгогдох эрхийн талаар нэлээн олон зөвлөмж, даалгаврыг өгсөн байна л даа. Тэгэхээр Сонгуулийн хууль чинь Засгийн газраас орж ирэх ёстой юм уу, эсвэл Улсын Их Хурал өөрсдөө энийгээ засаж явах ёстой юм уу? 5 намын төлөөлөл зөвшилцөл гээд байгаа.

Ялангуяа энэ сонгуулийн зардлыг бууруулахтай холбоотой, сонгуулийн санхүүжилт, ил, далд санхүүжилтийг бууруулах, ингэснээрээ шударга, тэгш өрсөлдөөнтэй сонгуулийг бий болгох гээд олон л асуудлыг бид нар Цэцийн дүгнэлтүүд ч гарлаа, ярилцаж байгаа. Тэгээд энэ тойрог, мандатын тоо, ноогдох сонгогчдын тооны харьцаа хэт зөрүүтэй байгааг арилгаж, сонгуулийн тойрог байгуулах энээ тэрээ гэдэг чинь Засгийн газрын хийх ажил яг мөн юм уу? Ийм юм Засгийн газарт даалгаж болох юм уу? Энэ чинь уг нь улс төрийн намууд өөрсдөө манлайлаад Улсын Их Хурал дээрээ л энийг хийдэг ажил байна л даа. Тэгэхээр бүх энэ гарсан зөвлөмжүүдийг нь бүгдийг нь Засгийн газар даалгачих нь хэр зохистой юм бол гэж харж байна.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Ер нь энэ хүний эрх, цахим технологитой холбоотой, хуулийн хэрэгжилттэй холбоотой, энэ шударгаар шүүлгэх эрх, бэлгийн хүчирхийллээс хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах гээд эд нар мэдээж Засгийн газар хууль хэрэгжилтийг сайжруулах, бодлогын түвшинд хууль тогтоомжоо сайжруулах гээд олон юмнууд нь болж л байгаа юм л даа. Зүгээр энэ сонгуультай холбоотой асуудлыг яагаад Засгийн газарт даалгаж байгаа юм гэдгийг, ялангуяа хууль тогтоомж энэ бүр концепцын тогтолцооны хувьд өөрчлөх том мандат эд нар өөрчлөх асуудал Улсын Их Хурлаар өөрчлөгддөг шүү дээ, тогтоогддог шүү дээ. Энийг эхлээд юу ч гэсэн ажлын хэсгээс асуучихъя тэгэх үү.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн тойрог, мандат хуваарилах асуудал мэдээж парламентын суудалтай, мөн парламент суудалгүй улс төрийн бүх намууд, мөн иргэний нийгмийн байгууллагуудын хүрээнд бас ойлголцож, улс төрийн зөвшилцөл, нийгмийн зөвшилцөл бас хангагдаж байж шийдвэрлэх асуудал гэдэг нь тодорхой байгаа. Энэ бол Улсын Их Хурлын тогтоолоор явагддаг. Гэхдээ энэ дотор нөгөө маш олон хүчин зүйлүүдийг харгалздаг. Тэр дотор жишээлбэл хүн амын тоо, сонгогчдын тоо, газар зүйн байршлууд энэ тэр гээд. Тэгэхээр энэ бүх бүртгэл, асуудал нь Засгийн газрын улсын бүртгэлийн байгууллага өөрөө бараг сонгуулийн тогтолцоо энэ зохион байгуулалтын 70 хувийг бас гарч авч гардаг. Тийм учраас энэ бүх тооцоо, судалгаа юмнуудыг нь хийх хүрээнд яг энэ хуулийг хийчих гэж шууд хэлээгүй байгаа. Ер нь энэтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой юман дээрээ анхаарч ажиллаж байгаарай гэдэг ийм санал, зөвлөмжийг өгч байх юм. Мэдээж энэ асуудал парламентынхаа улс төрийн намуудын эндээ асуудал шийдэгдэх нь тодорхой байгаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

О.Номинчимэг: Ерөнхий утгаараа гээд яаж байх шиг байна л даа. Гэхдээ цөмөөрөө тогтоол гаргаж байгаа юм чинь биелэгдэх боломж зарчмын хувьд юу вэ гэдгээ бас харчихвал. Жишээ нь ингээд 1.4 дээр сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш боломж олгох, тэнцвэртэй мэдээллийг хүргэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах гээд энэ Засгийн газар гэхээсээ илүү ингээд Сонгуулийн ерөнхий хорооны л хийдэг чиг үүрэгт нь л хамаарах юмнууд байгаа байхгүй юу. Даалгах. Тэгээд энэ чинь тогтоол авах юм, тогтоол гаргаж байгаа Засгийн газарт даалгаж байгаа гэхээр энэ чиг үүрэгт хамаарахгүй юмнууд л орчихсон юм шиг харагдаад байна л даа. Хугацаа бас байхгүй болохоор бүүр нарийн харж амжихгүй байна. Эхний хуудсаар л иймэрхүү юмнуудаа. Тэгэхээр илүү хуулийн биелэлт тал дээр, хэрэгжилт тал дээр тэгээд хууль тогтоомжийн сайжруулах тал нь болж байж болох юм. Зүгээр энэ сонгуультай холбоотой юмнуудаа цөмөөрөө жоохон дахиад харчихвал яасан юм бэ л гэдэг саналтай байна.

Д.Цогтбаатар: Ингэе Энхбаяр дарга ажлын хэсгийн даргын хувьд тэгвэл найруулга дээрээ, Их Хуралд оруулахаасаа өмнө бас найруулга дээрээ та нар ажиллачих. Энэ бол найруулгын юм янзалж болох асуудлууд байна гэж ойлголоо. Тэгье. Би тасалчихсан шүү дээ. Баасанжаргал гишүүн.

Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Х.Баасанжаргал: Тэгсэн тэгсэн. Энэ нөгөө 5 дугаар зүйлд заасан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар гээд энэ дээр манай Байнгын хорооны зүгээс нэг зүйлийг анхаармаар байна. Манай 26 оноос эхлээд Хүүхэд, гэр бүлийн шүүх байгуулагдах гэж байгаа. Тэгээд тэрэнтэй холбоотой зохицуулалтыг энэ тогтоолд нэгдүгээрт тусгаад, хоёрдугаарт яг энэ Хүүхэд, гэр бүлийн шүүх байгуулагдах, энэний бэлтгэл ажил хангах, салбар хоорондын асуудлууд маш олон асуудлууд байгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны гээд ингээд олон асуудлууд байгаа.

Тэгэхээр энэний салбар дундын зохицуулалтыг хангах ийм чиг үүрэг гэнэ дээр даалгаж өгөхгүй бол яг дангаараа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар гээд хэдийгээр бүлэг орж байгаа ч гэсэн нөгөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа маань Гэр бүл, хүүхдийн шүүх дээр ирэх жилээс эхлээд очно. Тэгэхээр тэрний бэлтгэл ажилтай холбож 1 зохицуулалт оруулах ийм саналтай байна гэсэн үг. Тэгээд салбар дундын асуудал бас нэлээн олон асуудлууд хамарна. Эрүүл мэндийнх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамных гээд. Манай Байнгын хороо бас энэ дээр жоохон анхаарахгүй бол болохгүй байна дарга. Таныг бас байхгүйд. Болсон.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр ингэе би ийм чиглэл өгчихмөөр байна Энхбаяр дарга. Сая Номинчимэг гишүүн, Баасанжаргал гишүүний ярьж байгаа зүйлсийг найруулгадаа тусгаад Их Хуралдаа өргөн бариад явчихъя. Оруулж болох асуудлууд байна гэж үзэж байна. Одоо тэгж хүндрүүлээд яах вэ. Би өөрөөр хэлбэл тийм чиглэл өглөө ажлын хэсгийн даргад. Санал хураахдаа би энэ томьёоллыг энэ найруулгадаа оруулаад яваарай гээд санал хураалгачихъя.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна. Тасалсан шүү одоо яг тийм. Үг хэлэх гишүүд тэгэхлээр байхгүй байна. Одоо ингээд санал хураалтад оръё.

“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг саяын 2 гишүүний хэлсэн Баасанжаргал, Номинчимэг гишүүний хэлсэн саналуудыг тусган баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Чуулганы нэгдсэн хуралдаанд энэ саналуудыг нь тусгаад оруулъя гэсэн ийм томьёололтойгоор санал хураалт явуулж байна. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн асуудалдаа оръё. Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг гишүүний асуудлыг хэлэлцэж хэдүүлээ эхэлнэ. 3 дугаар асуудал. Батчимэг гишүүний санал болгосон асуудлыг.

12.58 цаг

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг танилцуулна. Батчимэг гишүүний микрофоныг өгье.

П.Батчимэг: Хууль зүйн байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэд ялангуяа 18 нас хүрээгүй хүүхэд, залуучууд шинэ төрлийн бичил цахилгаан тээврийн хэрэгслүүд, түүний дотор суррон загварын цахилгаан дугуй, цахилгаан скүүтерээр замын хөдөлгөөнд оролцох явдал эрс нэмэгдсэн.

Мөн хүн амын хэт төвлөрөл, хотжилт, авто замын түгжрэлээс үүдэлтэйгээр нийслэл Улаанбаатар хотод нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, скүүтер, түрээсийн шинэ төрлийн үйлчилгээ бий болж, иргэдийн хэрэглээг өсгөж байна.

Үүний улмаас иргэд, явган зорчигч, цахилгаан дугуй, скүүтертэй холбоотой зам, тээврийн осол гэмтэлд өртөх өөрт болон бусдад эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол учруулах явдал эрс ихсэж нэмэгдэж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилийн хугацаанд цахилгаан дугуй, скүүтер, мопедоос үүдэлтэй нийт 985 шинэ тохиолдол бүртгэгдээд байна. Насны бүлгээр авч үзэхэд нийт осол, гэмтлийн тохиолдлын 39 хувийг 10-19 насны хүүхэд, залуус эзэлж байна. Мөн 2024 оны байдлаар манай улсад нийт цахилгаан дугуй, скүүтер, тээврийн хэрэгслийн түрээсийн үйлчилгээ үзүүлэгч Жет, Таобо, Эко байк/Есо bike/ гэсэн 3 аж ахуйн нэгж өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж байгаа юм.

Эдгээр аж ахуйн нэгжүүдийн сүүлийн 3 жилд импортоор оруулж ирсэн цахилгаан дугуй, скүүтерийн тоо 2022 онд 1050, 2023 онд 8157, 2024 онд 16783 болж өссөн. Цаашдаа ч улам өсөх хандлагатай байна.

Иймд Улсын Их Хурлын даргын 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 76 тоот захирамжаар төрөөс хүний эрх, эрх чөлөө, хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үндсэн зорилгын хүрээнд цахилгаан дугуй, суррон, скүүтерийн хэрэглээг зохицуулах талаар хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг миний бие ахлан, Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Лувсанжамц, Алтаншагай, Ганбат гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдсан.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2020 онд дэлхий даяар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах асуудлаар 74/299 дүгээр тогтоол баталж, зам, тээврийн ослын улмаас хүний амь нас хохирох, гэмтэл бэртлийн тохиолдлыг 2030 он гэхэд 50 хувь бууруулах зорилтыг дэвшүүлээд байна.

Энэхүү тогтоолоор замын хөдөлгөөний эмзэг оролцогчид болох явган зорчигч, унадаг дугуйн жолоочийн аюулгүй байдлыг хангахад онцгойлон анхаарал хандуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, арга хэмжээнүүдийг баталж, хэрэгжүүлэхийг гишүүн орнууддаа үүрэг болгосон.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Ажлын хэсэг өнгөрсөн 6 сарын хугацаанд хуулийн төсөл боловсруулах чиглэлээр холбогдох судалгааг гүйцэтгүүлэх, гадаад орны сайн туршлагыг судлах, мөн Монгол Улсын Засгийн газар холбогдох төрийн болон ТББ, мэргэжлийн экспертүүд, иргэд, олон нийт цахилгаан дугуй, скүүтер нийлүүлэгч, түрээсийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн саналыг авах зэрэг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан үе шаттай цогц ажлуудыг хийсний үндсэн дээр ийнхүү өнөөдөр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэхүү хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан болно.

Нэгдүгээрт, цахилгаан дугуй, цахилгаан, скүүтер, хувь хүний бичил, цахилгаан тээврийн хэрэгсэл гэсэн тээврийн хэрэгслийн ангиллын шинээр тодорхойлж, эдгээр тээврийн хэрэгслийг жолоодох насны хязгаар, тээврийн хэрэгслийн техникийн дээд хурд, тээврийн хэрэгсэлд зорчихыг зөвшөөрсөн замыг хуульчилсан болно.

2.Цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг жолоодон замын хөдөлгөөнд оролцогч жолоочийн эрх, үүрэг, жолоочид хориглох зүйлсийг мөн тусгасан болно.

3.Цахилгаан дугуй, скүүтерийн хөдөлгүүрийн хүч чадал, техникийн дээд хурд, тээврийн хэрэгслийн тоноглол зэргийг агуулсан цахилгаан дугуй, скүүтерийг ашиглах замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсэн шаардлагыг шинээр тусгав.

4.Нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх, мөн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр тодорхойлсон болно.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн болон гадаад орны туршлагыг судалсан талаар.

2025 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон энэхүү хуулийн төсөлд олон нийтийн нийтээс санал авахаар Улсын Их Хурлын Тамгын газрын d.parliament.mn цахим хуудсанд хуулийн төсөл, холбогдох судалгааг байршуулсан.

2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хурлын даргын 76 дугаар захирамжтай ажлын хэсгийн ээлжит хурлаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам, тээврийн яам, Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл гэсэн төрийн эрх барих төрийн эрх бүхий байгууллагуудын төлөөлөлд хуулийн төслийг танилцуулж санал солилцсон.

2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын даргын 76 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ээлжит хурлаар нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, скүүтерийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүд болох “Jet sharing” ХХК, “Би Эм Си групп” ХХК, “Эко технологи” ХХК компаниудын төлөөлөлтэй уулзалт хийж, хуулийн төсөлд үйлчилгээ эрхлэгчдийн саналыг тусгав.

2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг төрийн бус

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

байгууллагууд болох Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгэмлэг, ТББ-ын төлөөллүүдийг хүлээн авч хуулийн төслийн талаар танилцуулга хийж, санал солилцсон.

2025 оны 5 дугаар сарын 5-ны өдөр мөн ажлын хэсгийн ээлжит хурлаар хуулийн төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын гишүүн, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Эрдэнэбүрэн, Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогч Даваадалай болон бусад албаны хүмүүстэй уулзалт хийсэн.

2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын даргын 76 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хуулийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан ба хэлэлцүүлэгт ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Цогтбаатар, Уянга, С.Цэнгүүн, А.Ариунзаяа нарын болон иргэд олон нийт холбогдох төрийн болон ТББ, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 100 их гаруй хүмүүс иргэд оролцлоо.

2025 оны 5 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казакстан Улсад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, цахилгаан дугуй, скүүтерийн зам, дэд бүтэцтэй газар дээр нь очиж танилцах, тус улсын Дотоод хэргийн яам, Астана, Алматаагийн эрх бүхий албан тушаалтан, албаны хүмүүстэй уулзалт хийж туршлага судлах ажлыг зохион байгуулсан. Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Хууль тогтоомжийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан юм.

Эрхэм Хууль зүйн байнгын хорооны гишүүд анхаарал тавьсанд баярлалаа. Тэгээд асуултад хариулъя.

Д.Цогтбаатар: Батчимэг гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсэгт Ням-Очир Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, бригадын генерал, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Батзориг, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Зам, тээврийн хяналт төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга Очирбат. Батчимэг гишүүний зөвлөх Жамбалсүрэн. Ингээд хуульч, судлаач Нагважамц гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Номинчимэг гишүүнээр тасаллаа. Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

О.Номинчимэг: Цагтаа ирцэд орох юм бол гайгүй шүү дээ Энхбаяр гишүүн. Батчимэг гишүүнд баярлалаа. Энэ бас иргэдийн хувьд маш тулгамдаж байгаа асуудал.

Ер нь манай Улаанбаатар хотод ялангуяа иргэд, хүүхдүүдтэйгээ тайван амгалан, айж сандралгүйгээр явган замаар явж чадахаа больчихоод байна. Дээр нь авто замын хөдөлгөөнд оролцож байгаа этгээдүүдийн хувьд ч гэсэн хаанаас нь хэн нь гэнэт янз бүрийн дугуй юутай гараад ирэх үү гээд маш ийм түгшилтэй л юм. Хот маань өөрөө аюулгүй байдал хангах энэ асуудал маш их хүндрээд байгаа явган алхахад.

Ялангуяа тэгээд би 1, 2 л юм асууя гэж бодож байна. Ерөнхийдөө дэмжээд цааш нь бид нар энэ дээр энэ хуулийг хэлэлцээд явах нь зөв гэж харж байгаа. Нэг сонирхож байгаа юм бол манай хот ер нь явган иргэддээ маш аюулгүй хот болчихоод байгаа. Тэгээд хотын зүгээс энэ явган замаа илүү сайжруулъя, дугуйн замыг тусад нь байлгая, явган зорчигчдынхоо ийм таатай орчныг бүрдүүлье гэсэн уг нь бодлогыг бариад явган замуудаа сайжруулах, өргөжүүлэх гэдэг юмнуудыг аль болох л хийх гээд зорьж байгаа.

Тэгээд энэ хуулиар тэр скүүтер гээд юмыг чинь явган замаар бас унаж болохоор зохицуулаад байгаа юм уу, эсвэл явган замаар хорьчихоод байгаа юм уу? Яг үнэнийг хэлэхэд 3 компани янз бүрийн юм эко байк/есо bike/, скүүтер юмнууд оруулж ирдэг юм байна шүү дээ. Тэгээд хүүхдээ өглөө сургуульд нь би хүргэж өгдөг. Алхаж байхад ингээд урдаас нь юм гараад ирнэ тийшээгээ болохоор хойноос нь сигналдаад ингээд 7, 8 настай хүүхэд хүртэл ерөөсөө аюулгүй явган замаар алхах боломжгүй болчихсон. Энийг уг нь л цэгцэлчихвэл ядаж энэ алхаад дэлгүүр орчихъё, алхаад сургууль, цэцэрлэг орчихъё гэсэн хүмүүст уг нь их чухал ийм хууль байгаад байгаа. Тэгэхээр явган зам дээр скүүтер явах хэвээрээ байгаа юу энэ талаар ямар яаж зохицуулсан байгаа юм гэдгийг эхлээд асууя.

Д.Цогтбаатар: Батчимэг гишүүний микрофоныг өгье. Гүйцээгээд хариулъя.

П.Батчимэг: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ шинэ тутам хөгжиж байгаа бичил цахилгаан тээврийн хэрэгсэл дэлхий нийтийн чиг хандлага, дэлхийн улс орнуудын хөгжил, түүнийг дагаад нийслэл Улаанбаатар хотод сүүлийн 2019 оноос хойш маш эрчтэй ингээд хөгжөөд ороод ирлээ. Одоо гэхэд ерөөсөө хэдэн төрөл нь мэдэгдэхгүй, хаанаас оруулж ирж байгаа нь үл мэдэгдэх маш олон төрлийн скүүтер, энэ суррон дугуйнууд гадуур ингээд нийлүүлэгдээд явж байгаа.

Нэг талаасаа бизнес гэж харж болох боловч нөгөө талаасаа бид нар өнөөдөр энэ нийслэл хотын утааны асуудал, агаарын бохирдлын асуудал, дээр нь тэгээд замын түгжрэл, ингээд залуусын өөрсдийнх нь хүсэл эрмэлзэл энэ тренд болчихсон энэ дэлхий нийтийн чиг хандлагыг бид нар өнөөдөр яг энэ хуулиараа хориглох биш харин ч энийг хууль зүйн зохицуулалтыг хийж өгч хэрэглээгээ нэмэгдүүлэх ийм шаардлага бас урган гараад байгаа юм.

Тэгээд Номинчимэг гишүүн бас өөрөө нийслэлд ажиллаж байсан хүний хувьд бас одоо замын асуудлын хүндрэл байгааг ойлгож байгаа байх гэж би бодож байна. Яагаад гэхээр манай хотын төлөвлөлт анхнаасаа зам төлөвлөлт маш буруу явж ирсэн. Одоо бид нар явган хүний зам, унадаг дугуйныхаа замыг ч өнөөдөр

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

гүйцээж барьж чадаагүй байгаа шүү дээ. Тийм учраас дээр нь дахиад ингээд суррон, скүүтер гээд ороод ирж байгаа учраас энд ямар ч байсан нэгдүгээрт ерөөсөө замын асуудал маш чухал байгаа. Бид өнөөдөр амьдралынхаа шаардлага Улаанбаатар хотынхоо яг энэ байж байгаа байдалтай зохицуулаад үзэхээр энэ явган хүний замаар скүүтер зөрчихөөс өөр ямар ч өөр гарц байхгүй болсон.

Харин хууль өргөн баригдаад, дэмжигдээд, батлагдаад гарах юм бол хэрэгжилтийн шатанд нь бид замын асуудлыг, унадаг дугуйны замын асуудлыг ярих ийм цаг болсон юм байгаа юм. Тэгэхээр энд хурдны асуудал хурдны дээд хэмжээ тавигдчихсэн байгаа. Скүүтер бол дуртай хурдаараа явж байгаа. Суррон бүүр дуртай хурдан хурдаараа явж байгаа.

Тийм учраас энэ хурдны дээд хязгаарыг тогтоогоод өгчихсөн учраас явган хүн 5км зам, 5 миллийн хурдтай. Одоо энэ дээр 10 миллийн километр цагийн хурд тавьж өгсөн байгаа. Ер нь дэлхийн улс орнуудад 10-14, 15 л байдаг юм байна лээ.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье. Гүйцээгээд асууя.

О.Номинчимэг: Миний хувьд энэ явган хүний замаар ийм янз бүрийн цахилгаан хэрэгсэл явах нь өөрөө угаасаа явган хүний аюулгүй байдалд тухтай орчныг алдагдуулна гэж үзэж байгаа юм. Та ч гэсэн мэдэж байгаа байх ер нь дэлхийн энэ хүндээ ээлтэй 20 минутын хот гэдгийг хэрэгжүүлээд явдаг Европын улсууд Парис байдаг юм уу, Сөүл байдаг юм уу, Токиод байдаг юм уу явган хүний замаар өөр юм явуулдаггүй шүү дээ. Дэлхий нийтийн чиг хандлага гэж байгаа бол ямар ямар газар байгаа юм? Бид нар бас хармаар байна. Яг иргэд төвтэй хот төлөвлөлт дээр би явган замаар скүүтер, суррон янз бүрийн эко байк/eco bike/ унаж байгаа газар би мэдэхгүй. Тэгэхээр явган хүн 5км цагийн хурдтай явна тэгэхээр 10км цагийн хурдтайгаар скүүтер явахыг зөвшөөрнө гэхээр яах юм 10, 15 болчих юм бол, 12 болчих юм бол тэрийг хэн хэрэгжилтийг нь хангах юм, хэн цагдаа энэ дээр өө ч 10-аас илүү хурд хэтрүүлчихлээ гэдэг хэрэгжилт нь яаж хангах юм гэдэг дахиад асуудал гарах байхгүй юу. Энэ чинь хэрэгжихэд аягүй хэцүү шүү дээ. Явган хүний зам дээр хурдыг нь барьж явна гэдэг хэн хэрэгжилт, энийг нь хангаж явах юм?

Д.Цогтбаатар: Тодруулъя. Батчимэг гишүүний микрофоныг өгье.

П.Батчимэг: Тийм, Номинчимэг гишүүний тавьж байгаа асуудлыг ойлгож байна. Гэхдээ өнөөдрийн нийслэл хот өнөөдөр бид нар энэ замын асуудлыг бүр ярихгүй бол болохгүй болсон шүү дээ. Ганцхан тэр унадаг дууны замаа ч өнөөдөр бүтэн барьж чадаагүй. Тэрүүгээрээ бүр эрхээ хязгаарлуулчихсан ийм зорчигчид хүртэл зөндөө байгаа. Тэгэхээр бид нар өнөөдөр замын асуудлыг, зогсоолын асуудлыг энийг заавал давхар яригдаж байж хуулийн хэрэгжилт дээр ажиллах ёстой болсон юм. Тэгэхээр энийг үе шаттай хуулийн хэрэгжилтэд анхаарч Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн юутай хамтарч ажиллахаас өөр арга байхгүй.

Өнөөдөр чөлөөтэй зорчих хэсгийн авто замын замаар ч суррон дугуй давхиад 50-80 миллийн километр цагийн хурдтай явж байгаа. Тэгвэл энийг бид нар хуульчилж өгөөд дүрмээр биш, стандартаар биш хуулиар нь зохицуулалт

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

хийгээд өгчхөөд хурдны хязгаарыг тавиад өгөхөд хэрэгжилт дээр нь тээврийн цагдаагийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Батчимэг гишүүнээс Улсын Их Хуралд өргөн барьсан хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжиж байна. Нэлээн бас сайн судалгаанууд хийсэн юм байна гэж боловсруулалтын хувьд ч гэсэн нэлээн бас хөдөлмөр, цаг хугацаа зарсан гэдэг нь мэдэгдэж байна. Манай Засгийн газар ч гэсэн бас энэ яаралтай өргөн барьдаг хуулиуд дээрээ ийм түвшинд бас сайн судалж, өргөн барьж байвал зүгээр юм байна гэсэн бодол ч гэсэн төрснийг хэлье.

3 асуулт байна. Нэгдүгээрт энэ скүүтер, сурроны үйл ажиллагаа эрхлэх асуудал дээр Зөвшөөрлийн хуульд оруулж ийм үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдээр зөвшөөрлийн тогтолцоо оруулж ирэх юм байна. Тэгэхээр манай энэ Хассуурийн Ганхуяг гишүүн маань энэ Зөвшөөрлийн хуулийн парламент дахь загалмайлсан эцэг шахуу болчихсон ийм хүн байгаа. Энэ хуулиас гарсан ийм зөвшөөрлүүд нэмэх юман дээр нүд нь их хурц байдаг. Тийм учраас энэ Зөвшөөрлийн зөвлөлөөр заавал хэлэлцэж байж энэ шинэ зөвшөөрөл бий болговол оруулж ирэх бид ийм хууль баталсан юм. Тэгэхээр энэ Зөвшөөрлийн зөвлөлөөр нэгдүгээрт орсон уу? Заавал зөвшөөрлийн тогтолцоо руу оруулах зайлшгүй шаардлага байна уу гэдэг эхний асуулт байна.

Хоёр дахь асуулт нь Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулаад энэ үйл ажиллагаа дээр зөрчлийн шийтгэлүүд ноогдуулна. Миний ойлгож байгаагаар энэ цахилгаан дугуй, скүүтерийг ер нь хүүхдүүд их унаад байгаа. Тэгэхээр Зөрчлийн хуулийн маань энэ шийтгэл хүүхдүүдэд яаж үйлчлэх вэ? Өөрөөр хэлбэл, эрх зүйн хувьд 16-18 насны хүүхдүүд эрх зүйн бүрэн чадамжгүй хүүхдүүд байгаа. Тэгэхээр ийм эрх зүйн бүрэн чадамжгүй хүүхдүүд дээр энэ шийдэхэд яаж очих вэ? 16-аас доош насны хүүхэд хэрэв энэ зөрчлийг үйлдвэл энэ шийтгэл яаж буух вэ? Эцэг эх дээр нь шийтгэл нь, торгууль нь очих уу яах вэ гэсэн ийм асуулт байна.

Гуравдугаарт ажлын хэсэгт байгаа энэ цагдаагийнхнаас асуумаар байх юм. Энэ хиймэл оюун ухаан ашиглаад сүүлийн үед замын хөдөлгөөний шийтгэл их ноогдуулж байгаа юм байна лээ. Тэгэхэд энэ хиймэл оюун ухааны гээд энэнээс хойш ер нь шийтгэлүүд арай ихэдчихээд байна уу, үгүй юү? Энэ харьцуулсан судалгаа байна уу? Энэ хиймэл оюун ухаан ашигласнаас хойш шийтгэл хэд дахин нэмэгдчихэв? Энэ арай л их торгууль ирдэг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Батчимэг гишүүн хариулах уу?

П.Батчимэг: Энхбаяр гишүүнд баярлалаа. Үнэхээр энэ бас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг дэмжиж байгаад танд баярлалаа. Энэ их маш зөв оновчтой сайн асуулт байна. Би ч гэсэн өөрөө бас хууль санаачлагчийнхаа үүднээс энэ Зөвшөөрлийн тухай хуулийн энэ хуульд бас ингээд ороод ирж байгаад өөрөө анхандаа бас жоохон эргэлзэж л байсан.

Гэхдээ энэ үйл явц өөрөө Зөвшөөрлийн тухай хуулийн зорилт, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэхэд эрх

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох гээд ийм олон хяналтуудыг ингээд тавьж байгаа гээд заачихсан байгаа юм.

Тэгэхээр энэ явуулж байгаа, нийлүүлж байгаа энэ скүүтер, суррон дугуй, нийлүүлж байгаа бичил цахилгаан тээврийн хэрэгслийг нийлүүлж байгаа бизнесийн байгууллага, аж ахуйн нэгжүүд нь өнөөдрийг хүртэл ямар ч зөвшөөрөл, бүртгэлгүй гаалиар орж ирж байгаа шүү. Тэгэхээр энэ байдлыг яг одоо харж үзэхээр энэ нийлүүлэлт бүүр ингээд бүүр хязгаараа алдаж байгаа юм л даа. Тэгээд энэ дээр энэ үйл ажиллагаа нь өөрөө нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, орчиндоо аюултай үйл ажиллагаанд хамаарагдана гэж үзэж байгаа учраас л зөвшөөрөл олгоно гэж олгохоор тус хуулийн төсөлдөө тусгуулсан юм. Хүний эрүүл мэнд энэ бүх юмтай холбоотой учраас. Тэгээд манай нэмэлтээр хуулийн ажлын хэсгийн ахлагч хуульч Жамбалсүрэн дахиад тодруулаад хариулчих уу?

Д.Цогтбаатар: Эхлээд энэ, за тэгье нэмэлт 5 дугаар микрофон уу? 5 дугаар микрофон өгье.

Ө.Жамбалсүрэн: Гишүүний зөвлөх Жамбалсүрэн гэж хүн байна. Тэгэхээр Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Зөвшөөрлийн зөвлөлөөр орсон уу гэдэг асуулт шууд асууж байна. Тэгэхээр Хууль тогтоомжийн тухай хуульд болохоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, ер нь хууль санаачлагчийн зүгээс боловсруулж байгаа хуульд нэмэлт оруулах тухай хуулиудыг дагалдуулж боловсруулна гэсэн заалттай. Тэгээд яг хууль зохицуулах тухай хууль дээр Засгийн газраас санал авсан гэсэн ийм зохицуулалттай байгаад байгаа. Тэгээд Зөвшөөрлийн зөвлөлийг бид нарын ойлгож байгаагаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ахалдаг. Тийм учраас Засгийн газарт санал авах үед Засгийн газар энэ процедураа өөрсдөө хангаад Зөвшөөрлийнхөө зөвлөлөөр оруулаад ирэх ёстой байсан юм болов уу гэсэн ийм бодолтой байгаа.

Гэтэл өөрөө Засгийн газар саналаа өгөхдөө Зөвшөөрлийн зөвлөлөөр оруулаагүй гэдэг ийм зүйл тавьсан. Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар Зөвшөөрлийн зөвлөл эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих гэсэн ийм зохицуулалттай байгаад байгаа. Тэр нь эрх бүхий этгээд гэдэг нь ерөнхийдөө Засгийн газрын гүйцэтгэх түвшний байгууллага яам, агентлагаас зөвшөөрөл нэмэх тохиолдолд тэр зөвшөөрлийн зөв.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? 5 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Ө.Жамбалсүрэн: Тэгээд Засгийн газраас санал авах процедурынхаа шаардлагын дагуу 4 сарын 15-ны өдөр Засгийн газарт хүргүүлсэн. Ингээд 6 сарын 3-ны өдөр Засгийн газраас санал ирүүлсэн. Тэгэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хувьд энэ ажлыг зохион байгуулж оруулж ирэх ёстой байсан юм болов уу гэсэн ийм бодолтой байгаа. Хууль тогтоомжийн тухай хуулиар яг Улсын Их Хурлын гишүүн Ерөнхийлөгч эд нар хууль санаачлахад шууд ийм процедур яг шаардсан зүйл харагдахгүй байгаад байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сая тэгээд яг энэ зөвшөөрөлтэй холбогдуулаад Ганхуяг гишүүн энд ирчихсэн сууж байна. Энэ нэмэлт бас саяын асуултад Ганхуяг гишүүнд

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

хариулах боломж өгье. Ганхуяг гишүүний микрофоныг өгье. Бүртгүүлчихсэн байгаа юу?

Х.Ганхуяг: Баярлалаа. Энхбаяр гишүүн ялт ч үгүй манай Байнгын хороогоор дамжаагүй болохоор энэ саяын энэ юунуудыг харж амжсангүй л дээ. Зөвшөөрлийн зөвлөл гэдэг маань Засгийн газрын бүтцийн үйл ажиллагаа явуулдаг бас бүтэц биш шүү дээ. Тэр чинь төр, хувийн хэвшлийн хамтарсан зөвлөл байхгүй юу.

Зөвшөөрөл нэмнэ гэдэг процесс өөрөө эргээгээд эрсдэлийн үнэлгээ хийгддэг юм. Эрсдэлийн үнэлгээний аргачлал нь угаасаа Засгийн газар боловсруулаад Засгийн газрын тогтоолоороо баталчихсан байгаа. Тэгэхээр яг наад скүүтер унах нь өөрөө эрүүл мэнд, амь настай холбоотой болохоос биш тэр үйл ажиллагаа, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа асуудал нь наадах чинь би эрсдэлтэй үйл ажиллагаа гэж ерөөсөө харахгүй байгаа юм.

Тэгэхээр нэгдүгээрт хууль санаачилж байгаа бол хууль зөрчсөн, процессыг нь зөрчсөн байдлаар хууль санаачилж болохгүй л дээ. Ингэж оруулж ирж танилцуулаад, тэгээд тэр тайлбарлаж байгаа байдал ерөөсөө яасан ч хариуцлагагүй тайлбар хийгээд сууж байдаг юм. Тэгээд яах вэ зүгээр хэлэлцэх эсэхийг нь дэмжлээ гэж бодоход хэлэлцүүлгийн явцад тэр зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг нь эргэж харахыг бас хүсэж байна. Тэгээд Байнгын хорооны дарга, Энхбаяр гишүүнээс бас тус.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Юуны өмнө энэ хуулийн төслийг бас дэмжиж байгаа. Тэгээд энэ хуулийн төслийг санаачилсан Батчимэг гишүүн нийслэлийн иргэдийн хуралд бас бид хоёр нэг цаг үед нэг анги байсан. Энэ цаг үед бас ангид байгаа эрхэм гишүүндээ бас Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор шагнагдахаар болж байгаад бас баяр хүргэе. Тийм Батчимэг гишүүн. Энэ сайхан баярт мэдээний өдөр бас олон 10 хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, амь насыг хамгаалах нийгэмд зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болоод байгаа энэ зохицуулалтгүй байгаа тээврийн хэрэгслүүдийг зохицуулах хууль, эрх зүйн зохицуулалттай болох энэ маш чухал хуулийг санаачилж оруулж ирж байгаад бас талархалтай байна.

Сүүлийн үед гэхэд л 2023 онд 274, 2024 онд гэхэд 178 иргэн хүүхэд, залуучууд энэ чиглэлийн тээврийн хэрэгслээс болж замын хөдөлгөөний аюулгүй байдлын аваар осолд өртсөн гэсэн ийм харамсалтай дүн мэдээнүүд байна л даа. Тэгээд энэ нь өөрөө шууд энэ чиглэлийн нийтийн тээврийн хэрэгслүүдийг хууль, эрх зүйн зохицуулалттай болгох практик хэрэгцээ, шаардлага мөн үү гэвэл ялт ч үгүй л мөн. Тийм учраас энэ хуулийг ингээд яаралтайгаар оруулж ирж байгаа юм байна.

Тодруулж асууя. Энэ цахилгаан дугуй, энэ цахилгаан скүүтерүүд чинь тээврийн хэрэгслийн ангилал яаж орж ирж байгаа юм бэ? Тээврийн хэрэгсэл ер нь мөн үү үгүй юу яг нэгд? Энэ хэрэгслүүдийг тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд яаж бүртгэлжүүлэх юм бэ хууль батлагдсанаар? Одоо бол ямар ч бүртгэл юмгүй яваа. Мөн бүртгэлгүй учраас энэ скүүтерээр замын хөдөлгөөнд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага бас ямар ч зохицуулалтгүй, тодорхойгүй байгаа. Мөн энэ

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

тээврийн хэрэгслүүд чинь замын хөдөлгөөний техникийн хяналтын үзлэгт огт хамрагддаггүй байгаа. Хууль батлагдсанаар яаж хэрхэн хамруулдаг болох юм бэ? Мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал юманд огт хамрагддаггүй байгаа. Хууль батлагдсанаар энэ яаж асуудлыг шийдэх юм бэ? Мөн энэ чиглэлийн бизнес эрхэлж байгаа, үйлчилгээ үзүүлж байгаа компаниудын тавих хяналт, эрх зүйн зохицуулалтууд хууль батлагдсанаар яаж сайжрах юм бэ, дээшлэх юм бэ? Хууль батлагдсанаар энэ хэрэгслүүд шууд энэ автын замаар, автомашины замаар явж болох уу, болохгүй юу? Шууд хориглох юм уу? Өнөөдөр автомашинд мөргүүлчих гээд л яваад байгаа. Одоо явган хүний замаар явахаар энэ хэрэгслүүд чинь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Тодруулъя, гүйцээгээд асууя. Сандаг-Очир гишүүний микрофоныг.

Ц.Сандаг-Очир: Зориулалтын зам байхгүй учраас явган хүний замаар явахаар энэ хэрэгслүүд чинь явган хүнийг мөргөчих гээд байна. Өөрсдөө автомашинаар машины замаар явахаар автомашинд мөргүүлчих гээд байгаа бол явган хүний замаар явахаар явган хүнийг мөргөчих гээд байх ийм эрсдэл үүсэхээр байна. Тийм учраас манайд одоохондоо энэ тээврийн хэрэгслүүдийг явуулах замын нөхцөл байдал бүрдээгүй байгаа учраас яг аль замаар, явган хүний замаар явуулах юм уу, дугуйн зам тийм хүртээмжтэй биш, автомашины замаар явах явахгүй нь тодорхойгүй байна. Явах юм уу, явахгүй юм уу хууль батлагдсанаар? Энэ чиглэлийн мэдээллүүдийг өгөөч.

Д.Цогтбаатар: Батчимэг гишүүний микрофоныг өгье.

П.Батчимэг: Сандаг-Очир гишүүнд маш их баярлалаа. Хуулийн төсөлд ер нь энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд энэ өргөн мэдүүлж байгаа хуулийн төсөл дээр бүгдийг нь тодорхой заачихсан байгаа. Та тэгэхдээ энийг бас сайн харна биз. Тэгээд цахилгаан дугуй, цахилгаан, скүүтер гэсэн тээврийн хэрэгслийн ангиллын яг энэ хуулийн төсөлд шинээр тодорхойлолт оруулж ирсэн юм.

Цахилгаан дугуй гэдэг бол 1 хүн тээвэрлэх суудалтай, цахилгаан хөдөлгүүр болон дөрөө хосолсон гээд ингээд бүүр заагаад өгчихсөн. 25км цагаас хэтрэхгүй гээд хурдыг нь заачихсан. Одоо бүүр ямар ч дураараа явж байгаа байхгүй юу. Дураараа зорчиж байгаа. Тэгээд насны жолоодох насыг нь 16 нас гээд 16 насанд хүрсэн. Унадаг дугуйн явах зам нь юу гэхээр унадаг дугуйн замаар явах. Ийм зам байхгүй бол авто замын зорчих хэсгийн баруун гар талын захаар, эсвэл явган хүний замаар 10км цагийн хурдтай. 10км цагаас хэтрүүлэхгүй хурдтай явна гээд ийм тодорхойлолт шинээр оруулж өгсөн.

Цахилгаан скүүтер гэдэг нь 1 хүн тээвэрлэх суудалгүй нөгөө босоогоороо тэгээд цахилгаан хөдөлгүүртэй 25км цагаас хэтрэхгүй, бас 16 насанд хүрсэн.

Цахилгаан дугуй, суррон гээд энэ үйлдвэрийн нэр нь нэршлээрээ 1 хүн тээвэрлэх суудалтай, цахилгаан хөдөлгүүртэй гэж байгаа юм. Суудалтай энэ жижиг ногоон юу энэ тэр давхиад байгаа шүү дээ. Тэр нь хол 25км цагаас бас дээш хурдны юутай. 18 нас хүрсэн жолооны үнэмлэхтэй гээд. Зөвхөн авто замын зорчих хэсгийн баруун гар талын захаар явна гээд ингээд бүр тодорхой зааж өгсөн л дөө.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Нэмэлт хариултыг Жамбалсүрэн хуульч хэлэх үү?

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Ө.Жамбалсүрэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бүртгэлтэй холбоотой хяналт, үзлэг оношилгоо яах вэ гэж байна. Тэгэхээр энэ хуулийн төсөлд болохоор нийтийн хэрэгцээний цахилгаан дугуй, скүүтерийн үйлчилгээ эрхлэгч этгээдүүд болохоор үүрэгжүүлсэн байгаа үүрэг дээрээ. Тээврийн хэрэгслүүдээ өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдээ бүртгүүлэх, мөн хяналт, үзлэгт хамруулах гэсэн ийм үүрэг хүлээж байгаа.

Яаж хэрэгжих вэ гэхээр хууль батлагдсанаар энэ этгээдүүд нь ийм үүрэгтэй болсноор өнөөдөр Зам, тээврийн сайдын 2002 оны А222 тушаалаар авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам гэж байгаа. Тэгэхээр энэ журамд өөрчлөлт орно гэж ойлгож байгаа. Тэгээд энэ хэрэгжүүлэх асуудлыг Зам, тээврийн яам, нийслэлийн Засаг даргын түвшинд хэрэгжилт нь явна гэсэн ийм ойлголттой байгаа.

Шинэ тээврийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрч байгаа. Сая гишүүний хэлдгээр цахилгаан скүүтерийн тодорхойлолт, цахилгаан дугуйн тодорхойлолтыг тодорхойлж өгсөн. Яагаад шинэ тээврийн хэрэгсэл гэж байгаа гэхээр өнөөдрийн замын хөдөлгөөний дүрэм дээр мопед гэдэг нь 50км цагаас хэтрэхгүй хурдтай ийм тээврийн хэрэгсэл байгаа. Тийм учраас энэ дээр шинээр 25км гэдэг хурдны хязгаарлалтыг тогтоож өгснөөрөө энэ хувь хүний бичил цахилгаан тээврийн хэрэгслийг шинээр ингэж хуулиар тодорхойлж өгч байгаа гэж ойлгож болно. Бусад асуултуудыг нь гишүүн хариулсан гэж ойлголоо. Явган хүний замаар 10.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүн. Одоо 1 л тодруулна.

Ц.Сандаг-Очир: Энэ хуулийн төслийг чинь уншсан. Тэгээд энэ хуулийн төслийг бид нар унших гэхээсээ илүүтэйгээр энэ хүүхэд залуучууд, эцэг эхчүүдэд маш сайн сурталчлах ёстой юм байгаа юм. Тийм учраас би энэ хуулиар цаасан дээр бичсэн хуулийн чинь практик хэрэгцээ шаардлага, эрх зүйн зохицуулалтуудыг нь та бүхнээр яриулж иргэдэд мэдээлэл өгүүлэх үүднээс асуугаад байгаа юм. Тэгэхээр та бүхэн харин энэ цагийг ашиглаад маш сайн хуулиа сурталчлаад ийм ийм зохицуулалттай болох гэж байгаа юм, ийм ийм зохицуулалтгүй байгаа юм, хууль батлагдсанаар ийм эерэг үр дүн гарах юм гэдгээ маш сайн яриад хэлээд авах нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэ хуулийг тэр хэрэглэх тэр хүүхэд залуучууд, эцэг эхчүүд асар сайн мэдээлэлтэй болох ёстой гэдэг үүднээс маш сайн тодорхой асуугаад, асуултад та бүхэн бүрэн дүүрэн хуулиа сурталчлаад хариулаад өгөх нь чухал байгаа юм гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье. Сая үг хэлээд санал хэлчихлээ. Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Маш чухал хууль орж ирж байна. Яагаад чухал вэ гэхээр энэ бараг анхдагч байх. Сүүлийн үед үнэхээр энэ Улаанбаатар хотод, хөдөө орон нутагт ч гэсэн энэ мопед, скүүтер энэ хэрэглээ маш их өсөж байгаа. Тэгэхээр бид энэ хэрэглээ өсөж байгаа үед аливаа зүйлийг их хэт их хааж боохоосоо илүү энэ

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

бол түгжрэлийг бууруулах бас чухал хэрэгсэл юм. Хүүхэд залуучууд бас үүгээр зорчих сонирхолтой байна. Эд нар бүгдээрээ автобусанд тэр болгон суухгүй шүү дээ. Тэгэхээр энийг нь бид нар илүү хорихоосоо илүү яаж гоё замтай болох вэ, яаж аюулгүй байх вэ, тэр насны хязгаар бүх юмыг бид нар юун төлөө төр засаг гэж байгаа билээ энийг л зохицуулах дээр ажиллах ёстой. Тэгэхээр би Батчимэг гишүүнд бас юуг захих гэж байна гэхээр зөвхөн энэ хуулийн зохицуулалт гэхээсээ илүү энэ асуудлыг бүүр цогцоор нь та бүүр барьж аваад бүүр нийслэлтэй бүх л дүрэм, журмын хувьд бүгдийг нь сайхан барьж ингээд эхнээс нь дуустал хийгээд өгөөч гэж хүсэлт байгаа.

Яагаад гэхээр Их Хурал дээр ингээд олон асуудлууд замхраад байдаг. Яг тэрийг 1 гишүүн барьж аваад бүүр хөөцөлдөөд эхнээс нь ингээд яавал илүү үр дүнтэй байгаа. Тэгэхээр би таныг энийг чадна гэж бодож байна. Ер нь бид нар ингээд асуудлыг тойрохгүйгээр л ингээд сайхан бүгдийг нь шийдээд явах ёстой. Энэ дээр сая олон хүмүүс хэллээ тусгай замын асуудал. Тэгэхээр би жишээлэхэд Малайзад явж байхад Малайзад маш их мотоциклууд их байдаг. Тэгэнгүүт гол гол том замууд дээр дандаа мотоциклын зам нь ингээд тусдаа. Хятад ч гэсэн нэг хэсэг ингээд л дугуйн зам нь тусдаа байж байдаг. Тэгэхээр тэр олон дугуйн зам чинь машин замтайгаа нийлбэл үнэхээр маш замбараагүй байдал үүснэ, аюул осол их гарна. Тэгэхээр энэ бусад орны жишгээр энэ тусгай замуудыг л бас бий болгох талаар ажилламаар байгаа юм. Яагаад гэхээр Улаанбаатар хот их ойрхон. Ингээд л 4, 5км-т хүмүүс явмаар байдаг. Гэтэл аюулгүй байдлаасаа болоод л тэгээд л бүгдээрээ нэг нэг машин унаад ингээд явж байгаа юм. Тэгэхээр энэ түгжрэлийг бууруулах бас том хэрэгсэл юм.

Ер нь зүгээр би ингээд л харж байхад энэ машин зам барих бол маш их зардалтай. Дахиад л тусад нь скүүтерийн зам гэхээр нөгөө нарийн, өргөн нь яах юм байгаа юм? Тэгэхээр би энэ зарим явган хүний замын нэг хэсгийг нь бараг дугуй, скүүтерийн зам болгоод явган хүний замыг дээгүүр ингээд хийвэл илүү их хөнгөн зардал багатай болох юм уу л гэж зүгээр тооцоод хараад байдаг юм. Тэгэхээр та бас энийг зөвхөн хуульд биш юм гээд хаяхгүйгээр бас нийслэлдээ ингээд энэ асуудлыг нэлээн сайн мухарлаад ажиллаад өгөөрэй л гэж хүсэж байна. Гол нь энэ эдийн засгийн хувьд яг тэр өртөг, зардлыг нь тооцоод үзэхээр.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Санал хэлчихлээ.

Би товчхон асуулт асуучихъя. Энэ ингэж байна шүү дээ явган хүний зам дээгүүр 10км цагийн хурдтай явна. Хэрэв явах бол. Тэгтэл дугуйн зам байхгүй бол явган хүний зам дээр явна гэж байгаа юм. Дугуйн зам байгаа бол явган хүний зам дээр явах хориотой болох уу? Энэ нээлттэй байна. Өөрөөр хэлбэл, дугуйн зам байгаа газар явган хүний зам дээгүүр явах юм бол энэ эргээд санкцтай, торгуультай гэж ойлгох уу? Энэ хуульдаа яг тэрийг тодорхой заасан байгаа юу, эс үгүй бол энэ зүгээр тэгж ойлгогдохоор байгаа юу зохицуулалт нь?

Хэн хариулах уу? 5 дугаар микрофон өгье.

Ө.Жамбалсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр хуулийн төсөл дээр унадаг дугуйн зам буюу унадаг дугуйн эгнээ байхгүй тохиолдолд явган замаар зорчиж болно гэсэн ийм зохицуулалттай байгаа. Гэхдээ 10км цагаас хэтрүүлэхгүй гэдэг ийм хурдтай. Тэгэхээр зэрэгцээд мэдээж дугуйн

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

зам нь, явган зам нь зэрэгцээд байж байх юм бол дугуйн замаараа явах үүрэгтэй байхаар жолоочийн үүрэг дээр заачихсан байгаа. Тэгэхээр тэгж л ойлгож байна.

Д.Цогтбаатар: Өөрөөр хэлбэл, энэ дараа нь наадхыг чинь тайлбарлах хэрэв маргаан гарах юм бол энэ ингээд хориотой шүү гэж хэдүүлээ энийгээ ойлгохгүй бол сонгож явах боломжтой юм шиг ийм ойлголт төрж болохгүй шүү дээ.

Хоёр дахь асуулт цагдаагийнхнаас би 1 зүйл асуучихмаар байна. Харин нэгэнт энэ асуудал ороод ирсэн. Хүүхдүүд ийм гомдол яриад байгаа юм. Сурронтай ингээд явж байхад цагдаа нар түлхэж унагааж зогсоож байна. Их тийм зохисгүй зүй бусаар ингэж харьцаж зогсоогоод байна гээд. Тэгээд ийм хууль нь байхгүй байгаа үед энэ зохицуулалтаа нээрээ тэгж амьдрал дээр тэгж зүй бусаар яагаад байгаа юм уу? Би сүүлдээ бодсон л доо. Энэ хурдтай сурронтай явж байхад өөрөөр бас зогсоож чадахгүйдээ хүүхэд түлхэж унагаачхаад байгаа тийм юмнууд гараад байгаа юм уу? Тэн дээр цагдаагийнхан хариулж өгөөч.

Хэддүгээр микрофон өгөх вэ? 8 дугаар микрофон .

С.Очирбат: Гишүүний асуултад хариулъя. Ийм тохиолдол одоогоор цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй байгаа. Ер нь хяналт шалгалт хийх үед шаардлага тавихад зугтааж гэр хороолол, хорооллын гудамж замууд руу орох, явган зорчигчийн замаар явах ийм асуудлууд маш их гарч байгаа. Бид нар энэ ажлыг зохион байгуулахдаа ЕБС-ийн багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдтэй хамтран мэдээлэл өгөх, эцэг эхчүүд дээр нь баталгаа гаргах хэлбэрээр суррон буюу энэ мотоцикл төрлийн А ангилалд 18 нас хүрсэн хүн унах ёстой гээд одоогийн дүрмийн зохицуулалтын хүрээнд л хяналт шалгалтыг зохион байгуулж л ажиллаж байгаа.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж дууслаа гишүүд.

Хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Би өөрөө хууль санаачлагчийн нэг байгаа юм. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Хууль зүйн байнгын хороон дээр бас намрын чуулган дээр ажлын хэсэг гараад ажиллах байх гэж бодож байна. Үүнээс үүсэж байгаа бас нийгэм дэх гэдэг юм уу энэ хотын амьдралд бас үүсэж байгаа сөрөг нөлөөллүүд нэлээн байгаа. Энийг зөв дадалтай, зөв зохицуулж өгөх гэдэг агуулгаар байгаа. Тэгэхээр бас хуулийн төслийг өргөн барьсны дараа хориглох гэж байна, хязгаарлах гэж байна гэдэг зүйл байна лээ. Энэ агуулгаар нь би бас энэ хууль санаачлагч нэгдэж ороогүй. Энэ ерөөсөө зөв зохицуулъя гэдэг агуулгаар байгаа гэдэг зүйлийг нэгдүгээрт хэлмээр байна. Зөв зохицуулъя. Энийг хотын нэг хэсгээ, хотын энэ амьдралын нэг хэсгээ гэдэг зүйлийг эдгээр тээврийн хэрэгслийн хувьд хүлээн зөвшөөрч байгаа. Энийг харин зохицуулалттай иргэдийн зорчих хөдөлгөөнд саад болохгүй, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд нь халдахгүйгээр яаж зохицуулах вэ гэдэг гол үзэл санаа байгаа гэдэг зүйлийг хэлье.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Хоёрдугаарт энэ Ганхуяг гишүүний хэлж байгаа бас үнэн. Энэ зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэхгүй байх бодлогыг бид барих ёстой. Энэ дээр заавал зөвшөөрлийн асуудал уг нь байх шаардлагагүй байгаа. Энийг зүгээр ажлын хэсэг дээр ярилцаж болох байх. Аль болохоор энийг зүгээр стандартаа тавиад ингээд явахад боломжтой ийм үйл ажиллагаа байгаа. Тэгээд гишүүдийгээ бас уг асуудлыг бас дэмжээд хэлэлцэх эсэхийг нь шийдээд өгөөсэй гэж хүсэж байна. Баярлалаа

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Миний хувьд бас хуулийн төслийг дэмжиж байгаа. Ер нь яг хуулийн төслөөс бид нар үг бүрчлэн заалт болгоныг нь харах юм бол яг түрүүний Сандаг-Очир даргын асууж байсан яг тэр асуултуудын хариултууд яг энэ хуулийн төсөл дээр бүрэн бичигдсэн байгаа.

Мөн түүнчлэн бас онцгойлон хэлмээр байгаа юм бол бид нар суррон, цахилгаан скүүтерийн хэрэглээг хувь хүний хэрэглээ, нөгөө талаасаа яг энийг түрээсээр ашиглуулдаг хуулийн этгээдийн үйл ажиллагаа гэдэг талаас нь 2 ангилж оруулсан байгаад байгаа. Тэгэхээр яг эндээс юу харах вэ гэхээр 16 нас хүрсэн хүүхэд жишээлбэл яг хэт хурдтай буюу сурроныг унах эрх байхгүй. Суррон унах эрх нь 18 наснаас үүсэж байна.

Нөгөө талаасаа тухайн насанд хүрээгүй буюу 16 настай хүүхдийн хувьд эцэг эх хариуцлага хүлээх тэр боломжийг оруулж ирж байна. Мөн түүнчлэн яг тухайн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байгаа субъектүүдийн хувьд бүртгэлжүүлэх, техникийн хяналтад тээврийн хэрэгслээ оруулах гэх мэтчилэн нэлээн олон үүрэгжүүлсэн заалтууд орж ирсэн байна. Энэ дундаас би бас юмыг онцолж хэлмээр байгаа нь цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийн жолоочид дараах зүйлсийг хориглоно гээд. Яг бид нарын саяын хөндөж ирээд байгаа асуудлууд буюу нийтээр зорчих явган зорчигчид саад учруулаад байгаа осол аваар болох гээд байгаа зүйлсээс хамгаалах хориглолтын заалтуудыг оруулсан байна.

Жишээлэх юм бол, цахилгаан скүүтер, цахилгаан дугуй унахдаа зорчигч ачаа тээвэрлэх, цахилгаан дугуйн залуурыг сул тавьж жолоодох. Энэ бол маш их тохиолдож байгаа зүйлс буюу хүүхдүүд нөгөө ийм мундаг харагдах гэдэг юм уу сул тавих, огцом янз бүрийн хөдөлгөөнүүдийг хийх энийг буцааж хориглож байна.

Мөн түүнчлэн 1-ээс илүү эгнээтэй зам дээр зүүн эргэх, эсвэл буцаж эргэх гэж бүр дүрмийн зохицуулалтуудыг оруулж ирж байна. Явган хүний гарцаар цахилгаан скүүтер, цахилгаан дугуйг жолоодож замд хөндлөн гарахыг хориглож байгаа. Энэ бас аягүй чухал зүйл.

Яагаад гэхээр яг машин замаар явж байгаад явган хүний цагаан замаар шууд эргээд явдаг байхгүй юу. Гэтэл тэр заавал бууж байж өөрөө тэрийгээ хөтөлж гарах ёстой гэх мэтчилэн энэ нарийн зохицуулалтуудыг яг оруулж өгөөд энэ хуулийн төсөл, хууль батлагдсанаараа бид нар нэлээн олон зохицуулалтуудыг, нэлээн олон асуудлыг цэгцэлж чадах юм байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ хуулийн төслийг дэмжээд явах нь зүйтэй байх гэж харж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Дэмжсэн үг хэллээ.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбоотой гишүүд байр сууриа илэрхийлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу хуулийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

87.5 хувиар санал дэмжигдлээ.

Цааш үргэлжлүүлээд явъя.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

81.3 хувиар санал дэмжигдлээ.

Энэтэй харин холбогдуулаад нээрээ тэр зөвшөөрлийн, Батчимэг гишүүн ээ Зөвшөөрлийн тухай хууль дээр түрүүн Ганхуяг гишүүний ярьсан юмнуудыг бас та нар ер нь тусгаарай. Энэ хэлэлцүүлэх явцдаа Ганхуяг гишүүн бас яг Зөвшөөрлийн тухай хууль дээрээ нээрээ нэлээн нарийн мэдлэгтэй, ойлголттой байгаад байгаа учраас тэр уялдуулах нь зөв байх шүү.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

87.5 хувиар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг гишүүн? Аан тийм байсан. Уянгахишиг гишүүнээр танилцуулъя. Уянгахишиг гишүүн танилцуулна.

Ажлын хэсэгт талархал илэрхийлье. 4 дүгээр асуудалдаа оръё.

13.47 цаг

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Мөн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан горимын саналаар санал хураалт явуулах тул гишүүд санал хураалтдаа бэлдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

87.5 хувиар санал дэмжигдлээ.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё.

13.50 цаг

5 дугаар асуудал. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хууль нь Үндсэн хуульд нийцээгүй гэх Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр бүхлээрээ буюу тэдгээрийн зөрчилтэй зүйл, хэсэг, заалт хүчингүй болно гэж заасны дагуу Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг хүчингүй болсон байгаа.

Үүнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах нь зүйтэй гэсэн санал гарсан тул “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд 5 дахь асуудлыг хэлэлцэж дууслаа.

13.52 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 6 дугаар асуудал байгаа.

Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль зүйн байнгын хорооны даргад Улсын Их Хурлын хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Дамдины Цогтбаатарыг санал болгож

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

байгаа юм. Улираан сонгох саналыг оруулж байна. Цогтбаатарын товч намтрыг бас та бүхэнд танилцуулъя.

1970 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 1988 онд Монгол-Оросын хамтарсан 14 дүгээр дунд сургууль төгссөн. 1999 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, 1988 онд Австралийн их сургуулийг тус тус төгссөн.

Эрдмийн зэрэг цол АНУ, ХБНГУ, Нидерланд, Швейцарын Холбооны Улсад мэргэжил дээшлүүлсэн. Улс төр судлаач, Олон улсын хуульч мэргэжилтэй. Улс төр судлал болон Олон улсын хуулийн магистр зэрэгтэй. Орос, Англи, Герман, Кхмер, Тай хэлтэй.

1994-98 онд Гадаад харилцааны яамны Ази, Африкийн газар, Гадаад худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны газарт атташе. 1998-1999 онд МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль-Багш, 1998-2000 онд Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, хамтын ажиллагааны газарт мэргэжилтэн, 2000-2002 онд Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газрын дэд захирал, 2002-2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Гадаад бодлогын зөвлөх, 2008-2011 онд Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2011-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2012 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, 2012 онд Монгол Ардын намын нарийн бичгийн дарга, 2012-14 онд “Иксиллион” ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2014-2015 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд, 2015-2016 онд өмгөөллийн “Юстиэс консалтинг”, ХХК-ийн зөвлөх, 2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын хүний эрхийн дэд хорооны дарга, 2017 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2023 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, 2029 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байна.

Ингээд Дамдины Цогтбаатарыг улируулан сонгох саналыг дэвшүүлж байна. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Тийм. Энэ чинь процедураараа асуулт асуух юутай юм байна? Нэр дэвшигчээс асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Гишүүд асуулт. Одоо Байнгын хорооны даргыг сонгох асуудлаар үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Үг хэлэх гишүүд алга байна.

Дамдины Цогтбаатарыг Хууль зүйн байнгын хорооны даргаар дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Манайхан саналдаа бэлдээрэй. Түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

87.5 хувиар санал дэмжигдлээ.

2025 ОНЫ 07 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, ДААВАА ГАРАГ

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулна. Сандаг-Очир гишүүн ээ та танилцуулчхаарай.

Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул хуралдаан хаалаа.

14.03 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР